



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/667

Бсөнбулаг

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 41 дүгээр тогтоол, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Аймгийн 2023 оны төсвийн тодотгол батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэр сумын төвд "Хатуу хучилттай авто зам тавих" ажилд 2023 онд санхүүжүүлэхээр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтад батлагдсан 60,000,000 (жаран сая) төгрөгийг батлагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Төсөл, арга хэмжээнд зарцуулагдах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Дэлгэр сумын Засаг дарга (Д.Чинзориг)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О АМГАЛАНБААТАР

